|   | Цэгүүдэд байрлуулсан бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд цуглуулах, саармагжуулах                      | Шинээр үүссэн шимт хөрсний агуулахыг хийсэлтээс хамгаалж олон наст ургамлын холимог үрээр ургамалжуулах ажлыг гүйцэтгэсэн.                                                                     |
|   | 2 дахь түүхий эдийн хөрсний бохирдлыг цэвэрлэх, саармагжуулах                                               | Бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд 2 удаа цуглуулан саармагжуулсан.                                                                                                                      |
|   | 2 дахь түүхий эдийн хөрсний бохирдлыг цэвэрлэх, саармагжуулах                                               | 2 дахь түүхий эдийн талбайн талбайг 4-р сард хусуулж цэвэрлэсэн.                                                                                                                               |
| 4 | Газрын гадарга, хэвлий                                                                                      | Гравитацийн хүчний нөлөөллөөр явагдах геотехникийн процесст хяналт тавих                                                                                                                       |
|   |                                                                                                             | Нийт 5 удаагийн хөрсний суулт хагарал болж, нурж гулссан хөрсийг ачуулж, хөрсийг тогтоох тулгуур хийж, уулын хэсгүүдэд анхааруулах зөвлөмжүүдийг өгч байна.                                    |

**БАЙГАЛЬ ОРЧНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН 9-Р САРЫН БАЙДЛААР**

|   |                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                  |
|---|----------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | Автозамын сүлжээг оновчтой маршрутаар тогтоож олон салаа зам үүсгэхгүй байхад хяналт тавьж ажиллах | ЭКГ-4У №323 экскаваторын хөрс тээврийн 3.3км замыг 1.5 км болгон талын зайг 1.8км-ээр ойртуулсан. ЭКГ 10И №33 экскаваторын 3.2км замыг 1.3 км болгон талын зайг 1.9км-ээр ойртуулсан. ЭШ 20/90 №05 экскаваторын чиглэлийг өөрчилж 2.4км-ыг 2.1км болгон 0.3км-ээр талын зайг багасгасан. |                                                                                                                                                                                                                                                  |
| 5 | Ургамлан нөмрөг                                                                                    | Нөхөн сэргээлт хийсэн талбайд ургамлан бүрхэцийг тодорхойлох, эрүүл талбайтай харьцуулах                                                                                                                                                                                                 | 28 овгийн 64 төрлийн 77 зүйл бэлчээрийн, 22 овгийн 38 төрлийн 45 зүйл эмийн ашигт ургамал, чимэглэлийн 8 овгийн 8 төрөл 8 зүйл, 5 овгийн 5 төрлийн 6 зүйл балт ургамал, 3 овгийн 3 төрлийн 4 зүйл ургамал хүнсний ач холбогдолтой ургамал байна. |
| 6 | Амьтны аймаг                                                                                       | Ан амьтны ажиглалт, тандалтыг хийх                                                                                                                                                                                                                                                       | Хаврын мониторингийг 2024 оны 04 сарын эхээр хийж гүйцэтгэсэн бөгөөд 6 зүйл хөхтөн амьтад бүртгэгдсэн. Үүнээс монгол тарваганы тоо толгойн хувьд 15±3 бодгаль байх боломжтой бөгөөд 3 бүл байна.                                                 |
|   | Уурхайн нөлөөллийн бүсэд мал оруулахгүй байх арга хэмжээг авах                                     | Гэрээт харуул хамгаалалтын алба үйлдвэрийн талбайд мал оруулахгүй байхад анхаарч ажилласан.                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                  |

**ГУРАВ. Нөхөн сэргээлтийн чиглэлээр хийгдсэн ажил:**

**1. Техникийн нөхөн сэргээлтийн хүрээнд:**

Дотоод нөхөн дүүргэлтийг 3 байршилд Уул-1 хэсэгт 6814.9 мян.м<sup>3</sup>, Уул-2 хэсэгт 1987.1 мян.м<sup>3</sup> хөрсөөр дүүргэлт хийсэн.

**2. Биологийн нөхөн сэргээлт хүрээнд:**

Уулын ажлын онцлогоос хамааран уулын ажлын эцсийн хүрээ хязгаарын дагуу овоолгууд хэлбэржээгүй тул нөхөн сэргээлтийн оронд мод бут тарих, дүйцүүлэн хамгаалах ажлуудыг хийж байна.

Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах мод сөөгийг дотооддоо үржүүлэн бойжуулж нөхөн сэргээлтэд ашиглах мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж хэрэгжүүлэх зорилгоор 2024 онд 17000 мод тарих, шинээр 2 хүлэмж байгуулах, мод бутыг үрээр болон мөчрөөр тарихаар төлөвлөсөн.

2024 онд хаврын тарилтаар Нарийны голын татамд Улиас-2550ш, бургас 1600ш, шар хуайс 260ш хайлаас 850ш, ногоон дэд бүтэц хамгаалалтын ойн зурвас 1290ш, нийтийн хэрэгцээнд 6600ш, намрын тарилтаар үйлдвэрийн талбайд 550ш, Богд ууланд 5000ш, нийт 18700 ширхэг модыг тарьсан.

Хаврын тарилтанд Нарийны голын татмын нөхөн сэргээлтэд 5000ш улиас, хайлаас, бургас модыг тарьж хашиж хамгаалсан.

Мод үржүүлгийн газарт хамгаалалтын зурвасаар 1290ш хайлаасыг хашлагаар тарьсан.





## БАЙГАЛЬ ОРЧНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН 9-Р САРЫН БАЙДЛААР



Ажилчдын амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд компанийн 18 ажилтанд 6600ш хайлаас, 260ш шар хуайс, нийт 6860ш модыг ажилчдад өгч тариулсан.





Намрын тарилтаар үйлдвэрийн талбайд 550ш шинэс модыг тарьсан.



Багануур ХК нь Богд уулын нөхөн сэргээлтэд мод тарих төлөвлөгөөний дагуу 2024 оны намрын мод тарилтаар Бумбатын аманд 5000ш 2 настай шинэс модны тарьцыг тарьсан. Мод тарилтын ажлыг 2024 оны 10-р сарын 10-25-ны хооронд хийж гүйцэтгэв.







“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны тоо

| Модны тоо         | 2022 он | 2023 он | 2024 он<br>/хүлээгдэж буй<br>гүйцэтгэлээр/ | Нийт  |
|-------------------|---------|---------|--------------------------------------------|-------|
| Тарьсан модны тоо | 10,000  | 11637   | 18700                                      | 40337 |

Уурхайчдын “Харилцан хүндэтгэе” гэр бүлийн өдөрлөгөөр 120 ажилтан “Нэг өрх - Нэг мод” аяныг өрнүүлж гэр бүлийн хамт Нарийн голын эрэгт 120ш мод тарьсан.



Багануур ХК нь жил бүрийн бүх нийтийн мод тарих өдрөөр ажилчдыг хамруулан мод бутыг тарьж байна.






3. Мод бут арчилж хамгаалах хүрээнд:

Хавар 3, 4-р сард 120 улиас модыг хэлбэржүүлж, огтлон 1 настай мөчир 50000 бэлтгэсэн. Мод бутыг хэлбэржүүлэх болон шохойн сүүгээр шохойдож өвчин хортонгоос сэргийлэх, усалгаа арчилгааг хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.







#### 4. Мод үржүүлгийн ажлын хүрээнд:

Мод үржүүлгийн талбайд хайлаас, улиас, бургас, шар хуайс зэрэг навчит модыг үрээр болон модлог мөчрийн тарилтыг хийсэн. Шинэс, Голтбор, Буйлс зэрэг моднууд болон ил талбайд тарьсан Хайлаас, Улиас, Бургас, Шар хуайс зэрэг моднуудын арчилгаа усалгааг тогтмол хийж байна.

- ❖ Модлог мөчрөөр- Улиас- 10000, бургас-10000
- ❖ Үрээр – Хайлаас- 12000 шар хуайс- 8000

Навчит модны үр, мөчрийн тайрдсыг Уурхайн эдэлбэр талбай болон ойр орчмоос бэлтгэж байна.





## БАЙГАЛЬ ОРЧНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН 9-Р САРЫН БАЙДЛААР



Худалдан авах тендерт шалгарсан компанийн жимсний модны үрийн бэлдэц нийлүүлэлтээс шалтгаалан жимсний модыг үрээр тарих хугацаа оройтсон. Модлог мөчрөөр болон ногоон мөчрөөр 5 төрлийн жимсний модны үржүүлэг хийж туршсан. 180ш модны суулгац бэлдсэн. 2024 онд 2 хүлэмжинд тарилтыг хийхээр төлөвлөж байна.





**Мод үржүүлгийн талбайд бойжиж буй модны тарьц, суулгацын тоо**

| Суулгацын төрөл | 2022 онд | 2023 онд | 2024 онд | НИЙТ    |
|-----------------|----------|----------|----------|---------|
| Улиас           |          | 5,500    | 13,960   | 19,460  |
| Хайлаас         | 110,000  | 80,000   | 37,600   | 227,600 |
| Бургас          |          | 5,500    | 12,500   | 18,000  |
| Шар хуайс       |          | 38,000   | 14,260   | 52,260  |
| Шинэс           |          | 80,000   |          | 80,000  |
| Гүйлс           |          | 2,000    |          | 2,000   |
| Голт бор        |          | 2,000    |          | 2,000   |
| Жимсний мод     |          |          | 180      | 65      |
| Бүгд            | 110,000  | 213,000  | 78,320   | 401,500 |

Мод үржүүлгийн талбайд 2022 онд үрээр тарьсан 2 настай 120,000 гаруй хайлаасны суулгацыг бойжуулгын талбайд гаргахаар авч бэлдсэн боловч талбайн асуудлаас шалтгаалан 56000ш хайлааны суулгацыг бойжуулгын талбайд шилжүүлэн суулгасан.



Хайлаас модны 2 настай суулгацыг бортоглож усалгаа арчилгааг тогтмол хийсэн. Нийт 13000 ширхэг модыг бортоглосон.





5. Цэцэгжүүлэлт, тохижилтийн хүрээнд:

25 орчим төрлийн 5500 гаруй цэцгийн үрсэлгээг бэлтгэн ил талбайд шилжүүлсэн. Нийт 2300м<sup>2</sup> талбайг цэцэгжүүлсэн.



Гэрээт ажилчдыг 3-р сараас эхлэн авч ажиллуулж эхэлсэн бөгөөд 2024 онд 18 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

| Албан тушаал                                                      | Ажиллах хугацаа       | Төлөвлөсөн |
|-------------------------------------------------------------------|-----------------------|------------|
| Экологич                                                          | Үндсэн                | 1          |
| Байгаль орчны ажилтан                                             | Үндсэн                | 1          |
| Байгаль орчны туслах ажилтан                                      | Үндсэн                | 2          |
| Модны усалгаа, арчилгаа, үржүүлгийн газарт ажиллах гэрээт ажилтан | Гэрээт /8сар/         | 8          |
| Түр гэрээт ажилтан                                                | Гэрээт /Хавар, намар/ | 6          |
| Нийт                                                              |                       | 18         |



## БАЙГАЛЬ ОРЧНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН 9-Р САРЫН БАЙДЛААР

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд зохион байгуулсан “ЗӨВЛӨН ТУСЛАЯ” өдөрлөгөөр ажилтнуудад мод тарих арга аргачлалын талаар заавар зөвлөмж, мэдээлэл өгч өөрсдийн талбайд үржүүлсэн 2 настай 1000ш хайлаас модны суулгацыг ажилчдад тараасан.



2024 онд ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад туршлага судлах ажлыг хийгээд байна. Байгаль орчны 12 ажилтан нийт 6 компанийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.



Соёолж ХХК




Агроник ХХК



Сум дундын ойн анги



Төгөл ХХК



Ар гүнт “Инчон” Мөрөөдлийн төгөл





# БАЙГАЛЬ ОРЧНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН 9-Р САРЫН БАЙДЛААР

## Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

| №  | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Гүйцэтгэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|----|--------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Техникийн нөхөн сэргээлт | Дотоод нөхөн дүүргэлтийг алхагч экскаватороор буюу тээвэргүйгээр 2.3 сая.м <sup>3</sup> хөрсөөр нөхөн дүүргэлт хийнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Дотоод овоолгийн нөхөн дүүргэлтийг 6.8 сая.м <sup>3</sup> хөрсөөр нөхөн дүүргэлтийг хийсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 2. | Биологийн нөхөн сэргээлт | <p>Үйлдвэрийн талбай дахь мод бутны усалгаа, арчилгааг хийх, тохижилт, байгаль орчны ажлыг хийх</p> <p>Үйлдвэрийн талбай орчмыг цэцэгжүүлэх, цэцгийн мандлын үрсэлгээг бэлтгэх</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | <p>Үйлдвэрийн талбай дахь мод бутны усалгаа, арчилгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.</p> <p>25 орчим төрлийн 5500 гаруй цэцгийн үрсэлгээг бэлтгэн, нийт 2300м<sup>2</sup> талбайг цэцэгжүүлсэн.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| 3  | Тэрбум мод               | <p>Нэг сая модны стратеги төлөвлөгөөг боловсруулах</p> <p>Хүлэмжинд жимсний болон гоёлын модны үрсэлгээг хийх, усалгаа арчилгааг хийх</p> <p>Мод үржүүлгийн газрын ил талбайд болон хүлэмжинд навчит мод бутны үрсэлгээ хийх, усалгаа арчилгааг хийх</p> <p>Бойжуулгын талбайд мод бутны тарьцыг шилжүүлэн суулгах, арчлах</p> <p>Мод бутыг бортоглох, усалж арчлах</p> <p>Мод үржүүлгийн газрын барилга байгууламжуудыг засаж янзлах</p> <p>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 17000ш мод бут тарина.</p> <p>- Багануур дүүрэг Нарийн голын эрэг дагуу</p> <p>- Богд уулын нөхөн сэргээлт</p> <p>- Ажилчдын амьдрах орчныг сайжруулах</p> <p>- Уурхайн бүсийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх</p> <p>Тарьсан мод бутыг хашиж хамгаалах</p> | <p>Нэг сая модны стратеги төлөвлөгөөг боловсруулж бэлэн болгосон.</p> <p>Модлог болон ногоон мөчрөөр 3 төрлийн жимсний модны үржүүлэг хийж туршсан. 180ш модны суулгац бэлдсэн</p> <p>Ил талбайд нийт 78320ш навчит модны суулгацыг бойжуулж байна.</p> <p>2 настай 56000ш хайлаасны суулгацыг бойжуулгын талбайд шилжүүлэн суулгасан.</p> <p>Хайлаас модны 2 настай 13000 ширхэг суулгацыг бортоглосон.</p> <p>Мод үржүүлгийн газрын зөөврийн сууцыг янзалж байна. Хашааг шинэчилж байна.</p> <p>Нийт 18700ш мод, бутыг тариад байна.</p> <p>5000ш улиас, хайлаас, бургас тарьсан.</p> <p>5000ш шинэс тарьсан.</p> <p>6860ш хайлаас, шар хуайс тарьсан.</p> <p>1840ш шинэс, хайлаас тарьсан.</p> <p>Нарийны голын эрэгт тарьсан 5000ш модыг хашиж хамгаалсан.</p> |

**ДӨРӨВ. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хийгдсэн ажил:**

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын “Аварга тосон” орон нутгийн тусгай хамгаалалтын газар болон Төв аймгийн Баяндэлгэр суманд хийхээр төлөвлөсөн бөгөөд 2024 онд хийгдэх ажлын саналыг авсан. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

**ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

|   | <b>Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар</b> | <b>Хийгдэх ажил</b>                                                                       |
|---|----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум                | Аварга тосон, Бүрд нуурын хойд дэнжид хамгаалалтын зурвас байгуулж мод тарих, хашаажуулах |
| 2 | Төв аймгийн Баяндэлгэр сум                   | Ойн нөхөн сэргээлтэнд тарих модыг хашаажуулах хашааны тор авах                            |

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Аварга тосон, Бүрд нуурын хойд эргээр хамгаалалтын зурвас мод тарьж, хашаажуулсан. Үүнд:

Тарьсан модны төрөл: - Улиас 340ш  
 - Шар хуайс 2573ш  
 - Нийт 2913 ширхэг

Хашааны хэмжээ: - Урт 440м  
 - Өргөн 10м  
 - Талбай 4400м<sup>2</sup>







**Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| №  | Дүйцүүлэн хамгаалах зорилт                  | Хамгаалах арга хэмжээ                                                                                    |                                                                                                                           |
|----|---------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Аварга тосон ОНТХГН-ийг дүйцүүлэн хамгаалах | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв боловсруулах                                        | Орон нутгаас санал авч, төлөвлөгөө, төсвийг боловсруулсан.                                                                |
|    |                                             | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх | Аварга тосон, Бүрд нуурын хойд эргээр хамгаалалтын зурвас 2913 ширхэг мод тарьж, 4400м <sup>2</sup> талбайг хашаажуулсан. |
| 2. | Гүн галуутай ОНТХГН-т дүйцүүлэн хамгаалах   | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв боловсруулах                                        | Орон нутгаас санал авч, төлөвлөгөө, төсвийг боловсруулсан.                                                                |
|    |                                             | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх | 11-12-р сард хийнэ.                                                                                                       |

**Тав. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ**

Багануур ХК нь өөрийн эдэлбэр газарт үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дүүргийн иргэд, оршин суугчид суурин учраас нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй тул нөхөн олговор байхгүй.

**Зургаа. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ**

1. 2013 онд Монгол улсын шинжлэх ухааны академи Палеонтологийн төвтэй гэрээ байгуулан уурхайн ашиглалтын талбайд судалгаа хийлгэсэн. Судалгаагаар цаашид үйл ажиллагаа явуулж байхад явуулж байх үед соёлын өв илэрсэн тохиолдолд ШУА-ийн Палеонтологийн төвд хандан хуулийн дагуу хамгаалах, малтлага хийлгэх ажил зохион байгуулах зөвлөмжийг өгсөн.
2. Археологийн судалгааны ажлыг 2021 онд хийлгэсэн. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад газар дээр ил ямар нэгэн таних тэмдэггүй булш, хүний үйл ажиллагааны ул мөр, хөрс хуулалтын үед хүн малын яс, ваар сав, хүрэл, төмөр эдлэл болон бусад төрлийн эд өлгийн зүйлс илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээг авахыг зөвлөсөн.

| №  | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Зөвлөмж                                                                                                                                                                                                                                                                                                   |
|----|---------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Археологийн дурсгал             | Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад газар дээр ил ямар нэгэн таних тэмдэггүй булш, хүний үйл ажиллагааны ул мөр, хөрс хуулалтын үед хүн малын яс, ваар сав, хүрэл, төмөр эдлэл болон бусад төрлийн эд өлгийн зүйлс илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээг авахыг зөвлөсөн |
| 2  | Палеонтологийн дурсгал          | Судалгаагаар цаашид үйл ажиллагаа явуулж байхад явуулж байх үед соёлын өв илэрсэн тохиолдолд ШУА-ийн Палеонтологийн төвд хандан хуулийн дагуу хамгаалах, малтлага хийлгэх ажил зохион байгуулах зөвлөмжийг өгсөн.                                                                                         |



## Долоо. Осол, эрсдэлийн менежмент

1. Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх яаралтай тусламжийн эм тариа материал хэрэгсэл, ариутгал цэвэрлэгээ, хог хаягдал, анхан шатны бичиг баримтын стандартыг хангаж ажиллалаа. Сар бүр ХАБЭА-н нийт ажилтны сургалтаар анхны тусламжийн сургалтыг зохион байгуулж ажилласан.



2. Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн III шатны үзлэг хийх комисс нь компанийн хэсэг нэгжийн 2024 оны 1-3 дугаар улирлын ХАБЭА-н бичиг баримтууд, машин механизм, тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдхүүний техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, аюулгүй ажиллагаа, технологийн ажлын явц, паспортын мөрдөлт, ажлын байрны соёл, эрүүл ахуй, эрүүл мэнд, эмх цэгц, хүн нэг бүрийн ажлын, тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, түүний ашиглалтанд хяналт шалгалт хийсэн.

2024 оны 9-н сарын байдлаар аюулыг мэдээлэх хуудас болон 4000 дугаарын утсаар 11, хуудсаар 115, гар утасны аппликэйшнээр 221, нийт мэдээлэгдсэн 347 аюул эрсдэлийн мэдээллийг хүлээн авч, холбогдох хэлтэс, алба, хэсгийн дарга, ИТА нарт арилгах талаар тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар нийт мэдээллийн 100 % буюу 347-ийг аюулыг арилгуулж, эрсдэлээс сэргийлсэн.

Илэрсэн нийт мэдээллийн 16% буюу 56 нь их эрсдэлтэй, 20,4% буюу 71 нь дунд эрсдэлтэй, 63.6% буюу 214 нь бага эрсдэлтэй мэдээлэл эзэлж байна.

3. Болзошгүй осол, аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоног бүр 3-4 удаа ээлжит бус үзлэгийг тогтмол хийдэг бөгөөд 2024 оны эхний 9-н сарын байдлаар нийт 196 удаагийн үзлэгийг хийж, 117 зөрчил илрүүлсний 100% буюу 117-ыг нь тухай бүрт нь, хугацаатай үүрэг өгч арилгуулсан.

Илэрсэн зөрчлийн 51% буюу 60 нь цахилгааны аюулгүй байдлын, 39% буюу 45 нь технологийн, (зам, далан хамгаалалт г.м), 10% буюу 12 нь ажлын байр, орчны эмх цэгц, цэвэрлэгээтэй холбоотой зөрчил эзэлсэн.



Илэрсэн зөрчлийн 12 буюу 11.8%-ийг газар дээр нь шууд арилгуулсан бөгөөд 90 буюу 88.2%-ийг хугацаатай үүрэг өгч арилгуулсан байна.

“ХАБЭА-н сургалтын хөтөлбөр”-ийг 9 үндсэн, 32 дэд сэдвийн хүрээнд 12 цагийн багтаамжтай боловсруулан Үйлдвэрлэл, технологи эрхэлсэн дэд захирлаар батлуулан, Гүйцэтгэх захирлын А/109 тоот тушаалаар, батлагдсан хөтөлбөрийн дагуу 2024 оны 01-11 дүгээр сар хүртэл сар бүрийн 3 дахь долоо хоног бүр сургалтыг танхимаар явуулахад сургалтанд нийт 962 ажилтан хамрагдан 90 гаруй хувьтай явагдаж байна.

4. ЭАШТ, ГЭД, АУД сургуулилт: Хэсэг, нэгжийн амилуулах суурь тусламж, гал эсэргүүцэх, аваар устгах дасгал сургуулийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг хянах, чиглүүлэх, хамрагдалтыг сайжруулах чиглэлээр хяналт тавьж ажилладаг бөгөөд эхний хагас жилийн байдлаар амилуулах суурь тусламж, гал эсэргүүцэх, аваар устгах дасгал сургуулийг нийт 37 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 2164 ажилтныг хамруулсан.





5. 3-р сарын 28-ны өдөр 16:00 цагт орон даяар дуугарсан гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохиогоор Багануур ХК-ийн бүх хэсэг нэгжүүдийн ажилтнууд Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтсийн заавар, зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуульд хамрагдлаа



Гамшиг тохиолдсон нөхцөлд иргэн бүр бэлэн байх дадалд сургах тус сургуулилтад Багануур ХК-ийн 580 ажилтан, эрдэм шинжилгээний хуралд оролцохоор ирсэн ШУТИС-ийн эрдэмтэн багш нар, магистрант, докторант зэрэг 25 зочин, нийт 605 хүн оролцлоо.

6. **А.Химийн бодисын зориулалт:** Засварын цехэд аккумуляторыг сэргээн засварлахад – хүхрийн хүчил / $\text{H}_2\text{SO}_4$ /, хүчилтөрөгчийн цехэд 25%-ийн

аммиакийн уусмал / $\text{NH}_4\text{OH}$ /, аммонийн хлорид / $\text{NH}_4\text{Cl}$ /, засварын цехийн гагнуурчид – бура / $\text{Na}_2\text{B}_4\text{O}_7$ /-г тус тус ашиглана.

**Б.Химийн бодисын төрөл:** Хүхрийн хүчил /sulphuric acid- $\text{H}_2\text{SO}_4$ /, 25%-ийн аммиакийн уусмал /ammonia- $\text{NH}_4\text{OH}$ /, аммонийн хлорид /ammonium muriate- $\text{NH}_4\text{Cl}$ /, бура /borax- $\text{Na}_2\text{B}_4\text{O}_7$ /

| Химийн бодисын тооллогын хуудас |                 |                                                              |                                         |             |                     |
|---------------------------------|-----------------|--------------------------------------------------------------|-----------------------------------------|-------------|---------------------|
| Аймаг, нийслэл                  | Улаанбаатар хот | Улсын бүртгэлийн дугаар                                      | 9010001045                              |             |                     |
| Сум, дүүрэг                     | Багануур дүүрэг | Регистрийн дугаар                                            | 2008572                                 |             |                     |
| Аж ахуйн нэгжийн нэр            | Багануур ХК     | Үйл ажиллагааны чиглэл                                       | Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах |             |                     |
|                                 |                 | Зориулалтын агуулахтай эсэх                                  | Байгаа                                  |             |                     |
| №                               | Бодисын нэр     | Химийн томъёо                                                | Хэмжих нэгж                             | нийт хэмжээ | Хор, аюулын ангилал |
| 1                               | Аммиак          | $\text{NH}_4\text{OH}$                                       | л                                       | 0,12        | Онцгой цочроогч     |
| 2                               | Аммонийн хлорид | $\text{NH}_4\text{Cl}$                                       | кг                                      | 0.20        | цочроогч            |
| 3                               | Натрийн борат   | $\text{Na}_2\text{B}_4\text{O}_7 \cdot 10\text{H}_2\text{O}$ | кг                                      | 6           |                     |
| 4                               | Хүхрийн хүчил   | $\text{H}_2\text{SO}_4$                                      | л                                       | 0,74        | онцгой исэлдүүлэгч  |

❖ Химийн бодисын өрөөнд хадгалагдаж байгаа химийн бодисын тооллогын дүн мэдээг Дүүргийн МХХ, Цагдаагийн газар 3-р сард хүргүүлсэн. 11 сард химийн бодисын тооллогын дүн мэдээг дахин хүргүүлнэ.

❖ Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсад химийн бодисын хор аюулын лавлагааг хэрхэн унших, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалж, анхны тусламж үзүүлэх сэдэвт сургалтыг

- Уул – 1 тэсэлгээчин, гагнуурчин, нярав -11 ажилтан
- Уул – 2 тэсэлгээчин, гагнуурчин – 11 ажилтан
- ЭХНХ – реле хамгаалалтын засварчид – 7 ажилтанд орсон.

❖ Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд химийн бодисын болзошгүй ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний эрсдлийн үнэлгээг хийлгэж тусгасан.

❖ Химийн бодис болон хийнүүдэд ашиглах хадгалах тусгай зөвшөөрлийг авахад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн байх шаардлагатай. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдэн ерөнхий



үнэлгээ хийлгэх хүсэлтээ хүргүүлсэн. Дүгнэлт гарсаны үндсэн дээр нарийвчилсан үнэлгээ хийгдэнэ.

7. Тэсрэх материалын агуулах нь байнгын байнгын 24 цагийн харуул хамгаалалттайгаар ажиллуулж байна. Өрөмдлөгө тэсэлгээний ажил явуулах журам болон тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд нийцсэн тэсэлгээний ажлын паспорт боловсруулж, түүнийг мөрдөн ажилладаг.

#### Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл                                        | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ                                                                                                          | Хэрэгжилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|---|-----------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед үүсэх гэнэтийн аюул осол                  | Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах, анхан тусламжийн сургалтыг зохион байгуулах  | Яаралтай тусламжийн эм тариа материал хэрэгсэл, ариутгал цэвэрлэгээ, материалыг хангаж, сар бүр ХАБЭА-н нийт ажилтны сургалтаар анхны тусламжийн сургалтыг зохион байгуулж ажилласан.                                                                                                                                                                                                                                                                            |
| 2 | Хөдөлмөрийн аюулгүй бадйлыг хангах, эрүүл ахуйн бодлогыг хэрэгжүүлж ажиллах | ХАБЭА-н ээлжит болон ээлжит бус хяналтыг тогтмол хийх                                                                                               | 2024 оны 9-н сарын байдлаар аюулыг мэдээлэх хуудас болон 4000 дугаарын утсаар 11, хуудсаар 115, гар утасны аппликэйшнээр 221, нийт мэдээлэгдсэн 347 аюул эрсдэлийн мэдээллийг хүлээн авч, хугацаатай үүрэг даалгавар өгч, аюулыг 100 % арилгуулж, эрсдэлээс сэргийлсэн. 7 хоног бүр 3-4 удаа ээлжит бус үзлэгийг тогтмол хийсэн. 9-н сарын байдлаар нийт 196 удаагийн үзлэгийг хийж, 117 зөрчил илрүүлсний тухай бүрт нь, хугацаатай үүрэг өгч 100% арилгуулсан. |
|   |                                                                             | ХАБЭА-н сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулах                                                                                                  | 2024 оны 01 дүгээр сараас эхлэн сар бүрийн 3 дахь долоо хоног бүр ХАБЭА-н сургалтыг танхимаар явуулахад сургалтанд нийт 962 ажилтан хамрагдсан.                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|   |                                                                             | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах                                                                                                | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлийг тухай ханган ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
